



Сэндли

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

2022 оны 4-р улирлын үйл ажиллагааны тайлан

Phone: 7017-7700
info@sendly.mn
www.sendly.mn

© Сэндли ББСБ ХХК 2022

10-Р САР

“Сэндли ББСБ” ХХК нь нийт хувьцааны 29.9 хувийг олон нийтэд санал болгож, нээлттэй хувьцаат компани болсон.

10-Р САР

Stocklab-Монгол улсын хөрөнгийн зах зээлд гадаад улсаас оролцох боломжийг Стокларб үнэт цаасны компанитай хамтран Нирау, Сэндли АПП-д шинээр бүрдүүлсэн.

11-Р САР

БНСУ - ын KOSDAQ хөрөнгийн бирж дээр 2025 онд нээлттэй хувьцаа гаргахаар “ Шинхан секьюритис”-тай хамтын ажиллагааны гэрээ байгууллаа.

12-Р САР

“Хай Пэймэнт Солюшнс” ХХК албан ёсны түнш болох БНХАУ-ын “Wechatpay” цахим төлбөр тооцооны системийн үйлчилгээг Дорноговь аймгийн Замын-Үүд суманд нэвтрүүллээ

12-Р САР

Мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001 стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг бүрэн хангасан.



01. Бизнесийн үйл ажиллагаа

ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Харилцагчийн
тоо

7914

Зээлийн дундаж
олголт

2.8

 сая төгрөг


Сэндли ББСБ ХК-ын финтект суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлж зорилтод зах зээлд нийлүүлдэг. Бид 2021 онд жижиг дунд үйлдвэрлэгч, бичил бизнес эрхлэгчид зориулсан бүтээгдэхүүнээ зах зээл нэвтрүүлсэн бол энэ жил тогтмол орлоготой иргэдэд зориулсан хэрэглээний зээлийг шинээр зах зээлд гарган hiрау апп-аар дамжуулан зээлдэгчиддээ хүргэснээр нийт зээлийн **72.3** хувийг цахим зээл эзлэж байна.

Зээлийн багц:


Зээлийн багц бүтээгдэхүүнээр: **2022.12.31**

Төрөл	Бүтээгдэхүүний нэр	12/31/2022		Эзлэх хувь
		Зээлийн тоо	Үлдэгдэл	
Уламжлалт		279	6397.77	27.65%
Цахим		7483	16741.01	72.35%
	Дүн	7762	23,138.78	100.00%


Зээлийн бүтээгдэхүүн:



- Мерчант зээл
- Хэрэглээний зээл
- Даатгал
- E - зээл



- Цахим
- Уламжлалт



- Зээлийн шугам
- Лизингийн зээл
- Орон сууцны зээл
- ҮХХ барьцаалсан зээл
- Автомашин барьцаалсан зээл
- Бичил бизнесийн зээл
- Итгэлцэл барьцаалсан зээл

НИЙТ ХАРИЛЦАГЧ , НИЙТ ЗЭЭЛДЭГЧ



Бид Монгол улсын нутаг дэвсгэр бүрт үйл ажиллагаа эрхлэж буй бизнес эрхлэгчид хүрч үйлчлэх зорилтын хүрээнд Улаанбаатар хотод **6**, ОН-д **48** салбар нэгжээр дамжуулан зээлийг судалж, олголт хийж ажилласан байна.


НИЙТ ХАРИЛЦАГЧ , НИЙТ ЗЭЭЛДЭГЧ

Орон нутаг

48

Улаанбаатар

6



Бүс	12/31/2021			12/31/2022			Өөрчөлт	
	Зээлийн тоо	Үлдэгдэл	Эзлэх хувь	Зээлийн тоо	Үлдэгдэл	Эзлэх хувь	Үлдэгдэл	Эзлэх хувь
Дүн	3152	8,050.1	100.0%	7762	23,138.8	287.4%	15,088.7	187%

● БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сэндли мөнгөн гүйвүүлгын үйлчилгээгээ дараах орнуудаас Монгол улсруу шилжүүлэг гүйцэтгэлээ.



Мөнгөн гүйвүүлгын үйлчилгээ нь гадны орнуудаас эх орондоо суугаа хайртай дотны хүмүүстээ мөнгө шилжүүлэхээс гадна Монгол улсаас АНУ, Австрали улсуудруу шилжүүлгийн үйлчилгээг мөн явуулсан байна.

Sendly аппликейшнээр дамжуулан 2022 оны 12 дугаар сарын байдлаар нийт **8.26 сая** ам.доллар буюу **26.07 тэрбум** төгрөгтэй тэнцэх хэмжээний валютын гүйлгээг шилжүүлсэн байна.

МОНГОЛ - АНУ ГҮЙВУУЛГА МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ДҮН




Монгол улсаас АНУ руу шилжүүлэх мөнгөн гүйвүүлгын үйлчилгээг 2021 оны 03 дугаар сард, Монгол улсаас Австрали улсруу мөнгөн гүйвүүлгын үйлчилгээг 2022 оны 09 дугаар сард нэвтрүүлсэн бөгөөд 2022 оны 4-р улиралд нийт **455.8 сая** төгрөгийн гүйлгээг дамжуулаад байна.

АНУ - МОНГОЛ МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ДҮН



АНУ-аас Монгол улс руу шилжүүлэх мөнгөн гүйвүүлгын үйлчилгээг 2020 оны 05 дугаар сард анх нэвтрүүлсэн бол 2022 оны 4-р улиралд нийт **1.53 сая ам.доллар, 4.77 тэрбум** төгрөгийн гүйлгээг дамжуулаад байна.

АВСТРАЛИ - МОНГОЛ МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ДҮН



Австрали улсаас Монгол улс руу шилжүүлэх мөнгөн гүйвүүлгын үйлчилгээг 2021 оны 05 дугаар сард анх нэвтрүүлсэн бол 2022 оны 4-р улиралд нийт **183.6 мянган австрали долларын** гүйлгээг амжилттай дамжуулаад байна.

МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Япон улсаас Монгол улс руу шилжүүлэх мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 2021 оны 11 дүгээр сард анх нэвтрүүлсэн бол 2022 оны 4-р улиралд нийт **36.9 сая иений** гүйлгээг амжилттай дамжуулаад байна.

Европын холбооны 27 улсаас Монгол улс руу шилжүүлэх мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 2022 оны 6 дугаар сард анх нэвтрүүлсэн бол 2022 оны 4-р улиралд нийт **377.1 мянган еврогийн** гүйлгээг амжилттай дамжуулаад байна.


Sendly аппликейшнийг нэвтрүүлсэнээс хойш 2022 оны 4-р улиралд нийт **8.5 мянган** гүйлгээг амжилттай дамжуулж, өмнөх улирлуудаас өссөн үзүүлэлттэй байна.

SENDLY АПП БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ


Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх зорилгоор сайн дурын нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, дэлхийн монголчуудын төгөл, онлайн дэлгүүр, орон сууцны зээл зэрэг нэмэлт үйлчилгээнүүдийг мобайл аппликейшн дотор санал болгон ажиллаж байна. АНУ-д ажиллаж байгаа 2 хэрэглэгч Сэндли ББСБ-ын орон сууцны зээлээр Монгол улсдаа орон сууц худалдан авч 2022 оны 4-р улирлын байдлаар **191.9 сая төгрөгийн** үлдэгдэлтэй байна.

МӨНГӨН ГҮЙВУУЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА


2022 хүлээн авсан гүйвүүлгa дүн / USD /



Хүлээн авсан мөнгөн гүйвүүлгa



Орлогын бүтэц /2022.10.31/



“Сэндли ББСБ ХК-ийн нийт орлогын **17 хувийг** Олон улсын мөнгөн гүйвүүлгын орлого эзэлж байгаа бөгөөд 2022 онд нийт **8.5 сая ам.долларын** мөнгөн гүйвүүлгa гүйцэтгээд байна.

- БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сэндли ББСБ ХК нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, цөлжилт, газрын доройтолтой тэмцэх, ой мод, ойн санг нэмэгдүүлэх, усны эх үүсвэр, нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилтыг дэмжин "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд хамт олны санаачлагаар нэгдэж 2030 он хүртэл **1,500,000** ширхэг мод тарихаар батламжилсан.



Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, "Sendly Money Transfer", "Зөвийг Шүгэлдэгчид" ТББ-аас гадаадад ажиллаж, амьдарч буй монголчууддаа зориулан хэрэгжүүлж буй "Дэлхийн Монголчуудын төгөл" төслөлд Сэндли ББСБ ХК нь хамтран ажиллаж байна.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

МОНГОЛЫН АУТИЗМЫН ХОЛБООНЫ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Сэндли ББСБ ХК нь 2021 оны 6 дугаар сард Монголын аутизмын холбоотой хамтран ажиллах санамж бичиг байгуулсан бөгөөд хамтын ажиллагааны хүрээнд 2021 онд мөнгөн гуйвуулгын шимтгэл бүрт **1000 төгрөг**, 2022 онд мөнгөн гуйвуулгын гүйлгээний шимтгэлийн орлогын **2** хувийг уг холбоонд хандивлаж олон нийтэд аутизмыг таниулах, ойлгуулах, боловсролын хүртээмж, сургалт мэдээлэл, зөвлөгөө өгөх чиглэлд дэмжин ажилласан байна.



МББСБХ-ТОЙ ТУНХАГ БИЧИГ БАЙГУУЛЛАА

МББСБХолбоос гишүүн байгууллагуудаа уриалж Санхүүгийн зохицуулах хороотой хамтарч "Монгол Улсын нийгэм, байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, ногоон зээлийг дэмжихийн төлөөх хамтарсан тунхаг бичиг"-т гарын үсэг зурж Сэндли ББСБ дэмжин ажиллахаар боллоо.



ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр **10** дахь жилдээ үйл ажиллагаа явуулж буй Лантуун дохио ТББ-ийн зохион байгуулдаг Ид шидийн уут 2022 арга хэмжээнд оролцож алслагдсан дүүргүүдийн **100** хүүхдэд дулаан хувцас, гарын бэлгийг хүргэж ажиллаа.




02.Компанийн засаглал

● КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

"Сэндли ББСБ" ХК нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулж, Компанийн "Дүрэм" шинэчлэн баталж, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгосон.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц:



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮД:



Б.НАРАНБАТ
ТУЗ - ийн дарга
Санхүүч

Сангийн Яам
Төрийн Банк
Монголиан Финтек Групп ХК



М.ЦОЛМОН
ТУЗ - ийн гишүүн
Санхүүч

Сангийн Яам
Тариалан Эрхлэлтийг
Дэмжих Сан
Монгол Алт ХХК



Б.ЭРДЭНЭ
ТУЗ - ийн дарга
Санхүүч

Сангийн Яам
Төрийн Банк
Техбокс ХХК



Н.ЦЭВЭГМИД
ТУЗ - ийн гишүүн
Санхүүч

Райнос Инвестмент ҮЦК ХХК,
Мирэ Эссет Секьюритис ҮЦК ХХК



Л.НАРАНТУЯА
ТУЗ - ийн гишүүн
хуульч

Зоос Банк,
Төрийн Банк
Монголиан Финтек Групп ХК



Н.БИЛГҮҮН
ТУЗ - ийн гишүүн
Санхүүч

Сангийн Яам,
Selius Nomads ХХК,
Инвестлаб Ви Си ХХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:



Б.АНУЖИН
ТУЗ - ийн хараат
бус гишүүн

Азийн Сан,
Эрнст Энд Янг Монголиа Аудит ХХК
Central TV



Ц.САРУУЛТУЯА
ТУЗ - ийн хараат
бус гишүүн

Голомт банк
Тайвань ШУТИС
МУИС Бизнесийн сургууль



Б.ЦЭЛМЭГ
ТУЗ - ийн хараат
бус гишүүн

JP Morgan
SMBC Aviation Capital,
Хас Банк
Ашид Капитал ХХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн баталсан:

Төлөөлөн удирдах зөвлөл:

- ТУЗ-ийн дарга Б.Наранбат
- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Мөнхцэцэг

Эрсдэлийн удирдлагын хороо:

- Дарга Б.Цэлмэг
- Гишүүн Б.Эрдэнэ
- Гишүүн Ц.Саруултуяа

Аудитын хороо:

- Дарга Б.Анужин
- Гишүүн Б.Цэлмэг
- Гишүүн Н.Билгүүн

Цалин, урамшуулал, нэр дэвшүүлэх хороо:

- Дарга Ц.Саруултуяа
- Гишүүн Б.Анужин
- Гишүүн Л.Нарантуяа

- Компанийн бүтэц
- 2022 оны санхүүгийн тайланд “Шонхор үнэлгээ аудит” ХХК-аар хөндлөнгийн аудит хийлгэхээр сонгосон.

Компанийн бодлогын баримт бичиг:

- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
- Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын бодлого
- Залгамж халааны бодлого
- Ногдол ашгийн бодлого
- Эрсдэлийн удирдлагын бодлого
- Мэдээллийн аюулгүй байдлын бодлого
- Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл , сонирхолын зөрчлийг зохицуулах журам
- Мэдээллийн ил тод байдал , тайлагналын журам
- Хувьцаа эзэмшигчдийн зар хүргэх журам

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн баталсан:

“Сэндли ББСБ” ХК нь компанийн сайн засаглалыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж, хувьцаа эзэмшигчдэдээ урт хугацааны үнэ цэнийг бий болгох, Монгол улсад мөрдөгдөж буй хууль, журам, зааврыг бүрэн баримталж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ыг мөрдөн ажиллаж байна.

Сонирхолын зөрчилтэй хэлцэл	<ul style="list-style-type: none">2022 оны 4-р улиралд 2 гэрээ байгуулснаас 2 гэрээ хэрэгжиж байна.
Их хэмжээний хэлцэл	<ul style="list-style-type: none">2022 оны 4-р улиралд их хэмжээний хэлцэл байгуулаагүй.
Хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий гэрээ	<ul style="list-style-type: none">2022 оны 4-р улиралд 1 гэрээ байгуулснаас 1 гэрээ хэрэгжиж байна.

03. Санхүүгийн үзүүлэлт

АУДИТЛАГДААГҮЙ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Мянган төг	2022.09.30	2022.12.31
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,863,148	8,391,787
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	14,019,856	22,474,463
Нийт зээл	14,267,643	23,138,779
Эрсдэлийн сан	247,787	664,316
Хүүний авлага	1,156,919	1,473,141
Бусад актив	7,647,346	2,163,481
Үндсэн ба биет бус хөрөнгө	362,191	388,407
Нийт хөрөнгийн дүн	25,049,460	34,891,279
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	7,890,948	10,436,891
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	4,930,000	2,227,897
Бусад өглөг	1,326,672	800,690
Нийт өр төлбөрийн дүн	14,147,620	13,465,478
Хувьцаат капитал	7,828,500	11,178,500
Нэмж төлөгдсөн капитал	-	6,284,800
Бусад	19,273	14,717
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	3,054,067	3,947,784
Нийт өөрийн хөрөнгө	10,901,840	21,425,801
Нийт пассив ба өөрийн хөрөнгө	25,049,460	34,891,279

АУДИТЛАГДААГҮЙ ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

Мянган төг	2022.09.30	2022.12.31
Хүү болон түүнтэй адилтгах орлого	2,789,800	3,825,090
Хүү болон түүнтэй адилтгах зардал	1,001,090	1,474,621
Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал	237,510	656,523
Хүүгийн цэвэр орлого	1,551,200	1,693,946
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	4,030,260	5,889,385
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого, цэвэр	230,142	483,254
Нийт хүүгийн бус цэвэр орлого	4,260,402	6,372,639
Нийт үйл ажиллагааны орлого	5,811,602	8,066,585
Нийт үйл ажиллагааны зардал	3,186,189	4,567,835
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(52,873)	(93,934)
Татварын өмнөх ашиг	2,572,540	3,404,816
Орлогын албан татвар	246,281	340,531
Тайлант үеийн цэвэр ашиг	2,326,259	3,064,285

АУДИТЛАГДААГҮЙ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ХУРААНГУЙ

Мянган төг	2022.09.30	2022.12.31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,169,363	1,863,148
Цэвэр ашиг	2,326,259	738,027
Элэгдлийн зардал (+)	90,463	32,702
Ажлын капиталын өөрчлөлт	(13,049,242)	(3,637,725)
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(10,632,520)	(2,866,996)
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(214,737)	(58,918)
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргасан	15,842,431	8,354,749
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	(11,012,431)	(11,056,852)
Итгэлцлийн үйлчилгээ гаргасан	8,853,895	11,453,035
Итгэлцлийн үйлчилгээний төлбөр төлсөн	(3,542,853)	(8,931,179)
Хувьцаа гаргасан	1,400,000	9,634,800
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	11,541,042	9,454,553
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	693,785	6,528,639
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,863,148	8,391,787

АУДИТЛАГДААГҮЙ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Мянган төг	Хувьцаат капитал	Бусад өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	6,428,500	-	727,809	7,156,309
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	2,326,259	2,326,259
Сангуудын өөрчлөлт	-	19,273	-	19,273
Хувьцаат капиталын өсөлт	1,400,000	-	-	1,400,000
2022 оны 9-р сарын 30-ны үлдэгдэл	7,828,500	19,273	3,054,068	10,901,841
Залруулсан үлдэгдэл	7,828,500	19,273	3,209,757	11,057,530
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	738,027	738,027
Сангуудын өөрчлөлт	-	6,280,244	-	6,280,244
Хувьцаат капиталын өсөлт	3,350,000	-	-	3,350,000
2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	11,178,500	6,299,517	3,947,784	21,425,801

ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Шалгуур үзүүлэлт	Байх ёстой	2022.09.30	2022.12.31
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	43.4%	68.4%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	43.4%	68.4%
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	43.5%	61.4%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	13.2%	62.3%
Нэг зээлдэгч, түүний холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	30%-иас хэтрэхгүй	2.5%	9.3%
ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	70%-иас хэтрэхгүй	0.0%	0.0%
Нийт холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	25%-иас хэтрэхгүй	8.7%	5.9%
Нэг холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	10%-иас хэтрэхгүй	8.7%	4.2%
Үнэт цаасны эзэмшил / өөрийн хөрөнгө	50%-иас хэтрэхгүй	0.0%	0.0%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	+/-40%-иас хэтрэхгүй	14.1%	14.3%
Итгэлцлийн өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	72.4%	48.7%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	0.0%	0.0%
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	15%-иас хэтрэхгүй	0.8%	0.5%

● САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ХУВЬЦААНЫ ХАНШ



Үнэт
цаасны код

7914

Зах зээлийн
үнэлгээ

36,218,340.00

Хаалтын ханш
/2022.12.30/

162.11

Гаргасан
хувьцааны тоо ширхэг

223,570.00

IPO-с хойш:

8% ▲

P/E:

11.83

P/B:

1.69

04. Харилцагчийн үйлчилгээ

Чатботоор
мэдээлэл авсан

580

Олон улсаас
ирсэн дуудлага

495

Оператортой холбогдон
мэдээлэл авсан

698

Дотоодоос
залгасан дуудлага

1043

И-мэйлд
хариу өгсөн

630



05. Эрсдэлийн удирдлага

Дотоод аудитын тогтолцоо:

- “Сэндли” ББСБ ХК нь 2022 оны 12 дугаар сард шинэчлэн батлагдсан “Эрсдэлийн удирдлагын бодлого”-д хамгаалалтын гурван бүс бүхий эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог тусгасан. ББСБ нь хамгаалалтын 3 бүс тус бүрд хяналтын тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.

“Эрсдэлийн удирдлагын бодлого” шинэчлэн батлагдсантай холбоотой “ББСБ-ын хүлээж болзошгүй эрсдэлийн зохистой хязгаарыг тогтоох”, “Хөрвөх чадварын хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” зэрэг журмыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэхээр ажиллаж байна.

Мэдээллийн аюулгүй байдал, **ISP/IEC 27001:2013** стандарт



“Сэндли ББСБ” ХК нь Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO/IEC27001:2013 стандартыг нэвтрүүлэхээр үйл ажиллагааг 2022 оны 10 дугаар сараас эхлэн Пи Эс Эс Эй ХХК-аас зөвлөх үйлчилгээг авч өөрийн төв оффис болон Бөмбөгөр салбар дээр физик байршлыг тогтоон Олон улсын мөнгөн гүйвүүлгын үйлчилгээ, Зээлийн үйлчилгээ, Итгэлцлийн үйлчилгээг хамруулан өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж эхлээд байна.

Уг стандартын баталгаажуулалтын байгууллагаар Монсертф ХХК-аар дамжуулан Энэтхэг улсын QFS Management LLC компаниар баталгаажуулалтын аудитад хамрагдан Нэгдүгээр шатны аудитыг дуусган сайжруулалтыг хийж байна. Мөн түүнчлэн мэдээллийн аюулгүй байдал чухлаар тавигдаж буй учир бид системийн аюулгүй байдалд хяналт тавихаар Энэтхэгийн мэдээллийн системийн аюулгүй байдлын компани болох SISA-тай хамтран эмзэг байдлын болон системд халдах байдалд үнэлгээ хийлгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.



2022 оны 4-р улирлын
үйл ажиллагааны тайлан

"Сэндли ББСБ" ХК

70177700

www.sendly.mn